

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР, ХАРЬЯА НИЙТИЙН НОМЫН
САНГУУДАЙ ХАМТРАН ИЛҮҮ ИХ УНШЪЯ УРИАН ДОР “ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСЭГ,
НОМЫН БАЯР-2023” ХАВРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛСАН
АЖЛЫН ТАЙЛАН**

2023.06.05

Дархан-Уул аймаг

Зорилго: “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль”, “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023” арга хэмжээг улс орон даяар өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүлж, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, хүүхэд залуусын сурах эрмэлзэлд дэмжлэг үзүүлэх, ном эрдмийг түгээн дэлгэрүүлэхэд оршино.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САН:

НЭГ. Соёл олон нийтийн ажлыг зохион байгуулсан ажлууд:

Нийт 38 нэр төрлийн 76 үйл ажиллагаанд 10,516 хүнийг хамруулан ном хэвлэл, соёл олон нийтийн ажлыг зохион байгуулж соёлын боловсролыг сурталчлан ажиллалаа.

А). “МИНИЙ МЭРГЭЖИЛ ХАМГИЙН САЙХАН” уулзалт, нэвтрүүлэг

Дархан-Уул аймгийн Төв номын сан байгуулагдсаны 60 жилийн ойг угтан, Үндэсний бичиг соёл номын өдрүүдийн хүрээнд бэлтгэн хүргэж буй “МИНИЙ МЭРГЭЖИЛ ХАМГИЙН САЙХАН” цуврал нэвтрүүлгийн дугаарт:

- ✓ Дархан-Уул аймгийн Төв номын сангийн ахмад номын санч, МУСТА, Соёл судлалын магистр, доктрантур Ч.Бадамцэцэг,
- ✓ Дархан-Уул аймгийн Төв номын сангийн ахмад номын санч, МУСТА Н.Солонго
- ✓ Дархан-Уул аймгийн Төв номын сангийн ахмад номын санч, МУСТА Ц.Долгорсүрэн нарын 3 удаагийн уулзалт ярилцлагыг нэвтрүүлгийг бэлтгэн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд хүргэлээ.

Б) “ЗОХИОЛЧ ба УНШИГЧ” уулзалт

33 дахь удаагийн Үндэсний номын баярыг тохиолдуулан “ХАВРЫН НОМЫН БАЯР - ХҮҮХЭД БҮР УНШИГЧ” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж “ЗОХИОЛЧ ба УНШИГЧ” уулзалтыг зохион байгуулав. “УУТАН ХАЦАРТ” номын зохиолч МУСГЗ, сэтгүүлч Ө.Рагчаасүрэн, зураач Б.Нямдаваа нарын оролцсон “ЗОХИОЛЧ-ХҮҮХЭД” уулзалтад **50 гаруй** сурагч, номын санчид оролцов. Оюуны-Ирээдүй цогцолбор сургуулийн 6-11 анги, Од цогцолбор сургуулийн 10-2 ангийн сурагчид оролцож “Уутан хацарт” номын талаар, зохиолын дүрүүд, зургийн талаарх сонирхолтой чөлөөт ярилцлагуудыг өрнүүлэв.





В) "ШИНЭ НОМЫН БАЯР" номын нээлт

Радио телевизийн Тэргүүний ажилтан, МҮОНРТ-ийн ахмад ажилтан Д.Жамсрангийн 3 дахь бүтээл болох "Мэдлэг ба сэтгэлгээ өдрийн тэмдэглэл" номыг Үндэсний бичиг соёл, номын өдрүүдийн хүрээнд өлгийдөн авав. "ШИНЭ НОМЫН БАЯР"-ын нээлтэд **40 гаруй** уншигч, номын садан найз нөхөд нь оролцов.



ХОЁР. Соёл олон нийтийн ажилд оролцсон байдал:

А) Нийтээр тэмдэглэх болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийн хүрээнд "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд"-ийг Дархан хотын номын баяр- ХҮҮХЭД БҮР УНШИГЧ урианд дор зохион байгуулж ирлээ.


Энэ удаагийн номын баярын зохион байгуулалтад Дархан сумын ЗДТГ, Соёл урлагийн газар, Залуучууд театр, Хүүхдийн номын ордон, Их дээд сургуулиуд, ЕБС, Соёлын байгууллагууд болон Интер номын дэлгүүр, All in one, Дархан номын түрээс худалдаа, Дархан сумын Ахмадын хороо, багийн дэргэдэх ахмадын зөвлөлүүд зэрэг төр, хувийн хэвшлийн нийт 20 гаруй байгууллагын 100 гаруй хүн хамтран зохион байгуулав. Номын баярыг үзэж сонирхохоор СӨБ-ын байгууллагын 500 гаруй, ЕБС-ийн 600 орчим хүүхэд, иргэд олон нийт, оюутан залуучуудын төлөөлөл 300 гаруй хүмүүс хүрэлцэн ирж, нийтдээ **1500** хүний оролцоотойгоор номын баярын нээлтийн өдрийн үйл ажиллагаа өндөрлөлөө.



Б) УБТЗ-ын тусгай хөтөлбөрийн зочдод номын сангийн боловсролын хөтөлбөрийг хүргэхэд хамтран ажиллав.

Монгол Улсын Засгийн газар 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан УБТЗ тусгай хөтөлбөртэй аяллуудыг зохион байгуулж эхэлсэн.

Улаанбаатар Төмөр замын Аялал жуулчлалын төвөөс нийслэлийн ЕБС-ийн 6-9 дүгээр ангийн 72 хүүхдийг хамруулсан "Хүүхдийн галт тэрэг"-ний 2 шөнө 1 өдрийн аяллыг Дарханы "Saikhnaa's Catering"-тай хамтран зохион байгуулсан байгаа бөгөөд Дархан хотоор аялахын зэрэгцээ Төв номын сангийн үйл ажиллагаатай танилцан "Монгол бахархал" боловсролын хөтөлбөрт хамрагдав.



В) Н.Түвшинтөр даргатай Дархан сумын 15 дугаар багийн хамт олонд Төв номын сан болон Дархан хотын байгууллага хамт олон, иргэдийн сэтгэл шингэсэн хандивын 285 боть номыг хүлээлгэн өглөө. /15/



Дархан-Уул аймгийн Төв номын сангийн үйл ажиллагаа буюу “Номын сантай баг” хандивын аяныг дэмжин дараах байгууллагууд номын хандив өргөж, нийт **419** боть номоор фондоо баяжуулах буюу Дархан сумын гэр хорооллын 2 багт шинээр гэрээр ном олгох тасаг нээж өглөө. Үүнд:

- | | |
|---|----------------|
| 1. Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын хамт олон | - 147 боть ном |
| 2. Соёл урлагийн газар | - 38 боть ном |
| 3. “Орхон 21-р зуун төв” | - 41 боть ном |
| 4. МҮОНРТ-ийн ахмад ажилтан Д.Жамсран
"Мэдлэг ба сэтгэлгээ өдрийн тэмдэглэл" | - 5 боть ном |
| 5. Зохиолч Ойдовын Цэнд | - 50 боть ном |
| 6. Эрүүл мэндийн байгууллагуудын сувилагч нар | - 138 боть н |



Сувилагчдад зориулан оюуны хөрөнгө оруулалт хийдэг "СУВИЛАХУЙН ҮЙЛСТЭН" үйл ажиллагааг УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлангийн ажлын албанаас 2 дахь жилдээ зохион байгуулсан бөгөөд тус өдөрлөгт оролцсон сувилагчид нийгмийн хариуцлагын хүрээнд нэгдэн Дархан сумын 15, Малчин багийн төвүүдэд байгуулагдах “ГЭРЭЭР НОМ ОЛГОХ” тасагт 138 боть номыг хандивлалаа.



ГУРАВ. Уралдаан тэмцээн зохион байгуулсан байдал:
ДӨРВӨН УРАЛДААНД 278 ХҮН ОРОЛЦОВ

А) Үндэсний бичиг соёл, номын өдрүүд - 2023 үйл ажиллагааны хүрээнд "УГИЙН БИЧИГ ХЭН САЙН ХӨТЛӨХ ВЭ" уралдааныг [УИХ-ын гишүүн Болдын Жавхлангийн ажлын алба](#)-ны дэмжлэгтэйгээр зохион байгууллаа. 50 гаруй иргэд 23 бүтээлээр шалгаруулалтад оролцлоо.

- ✓ 1 дүгээр байранд Дархан сумын 7 дугаар багийн иргэн Гэмбэлийн Мягмар "Гэр бүлийн ургийн хэлхээг 9 үеэрээ хөтөлсөн" номоор
- ✓ 2 дугаар байранд Дархан сумын 10 дугаар багийн иргэн Дансрангийн Хумбугай "Гэр бүлийн ургийн хэлхээг 8 үеэрээ хөтөлсөн ургийн ном"-оор
- ✓ 3 дугаар байранд Дархан сумын 10 дугаар багийн иргэн н.Долгор "Өөрийн талын болон гэр бүлийн ургийн хэлхээг 8 үеэрээ хөтөлсөн ном"-оороо тус тус шалгарч, мөнгөн шагнал, үнэ бүхий зүйлээр шагнууллаа.



Б) Үндэсний бичиг соёл, номын өдрүүд болон Дэлхийн номын өдрийг угтан зохион байгуулсан "СУДАР ЭРДЭНЭ" богино өгүүллэгийн уралдаанд нийт 80 гаруй бүтээл ирлээ. Тус бүтээлүүдээс 2023 оны 05 дугаар сарын 27-ны өдөр 2 дугаар шатанд 28 бүтээлийн эздийг оролцуулахаар шалгаруулсан бөгөөд уралдааны удирдамжид заасны дагуу

өгүүллэгийн хугацаа, уран яруу уншсан байдал, өгүүлэмж, хөгжим дуу, орчин зэргийг харгалзан дүгнэв.

- ✓ Цэцэрлэгийн нас: - Г.Золбаяр 12 дугаар цэцэрлэгийн Бэлтгэл А бүлэг
- Э.Энххүслэн 12 дугаар цэцэрлэгийн Бэлтгэл А бүлэг
- Ү.Амгалан 7 дугаар цэцэрлэг
- Б.Урантуяа Бэлтгэл бүлэг
- Т.Оюунжаргал Бэлтгэл бүлэг
- С.Баярцэнгэл
- Н.Мөнх-Аялгуу Орхон сумын 9 дүгээр цэцэрлэг
- ✓ 1-5 дугаар анги: - Ш.Мөнх-Учрал 16 дугаар сургуулийн 5б анги
- А.Гийгүүлэн Оюуны-Ирээдүй цогцолбор сургуулийн 3-1 анги
- О.Сумъяа Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 5в анги
- К.Берикгүль Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 2в анги
- Баярцэцэг- Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 4в анги
- Ү.Хулан - Оюуны-Ирээдүй цогцолбор сургуулийн 4-2 анги
- Б.Гэгээ Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 4в анги
- Э.Энх-Учрал 9 дүгээр сургуулийн 2г анги
- ✓ 6-8 дугаар анги: - Ц.Болор Шарын гол сумын 6 дугаар сургуулийн 6а анги
- Т.Марал-Оюу Оюуны-Ирээдүй цогцолбор сургуулийн 6-10 анги
- Н.Уранбилэг Шарын гол сумын 6 дугаар сургуулийн 6а анги
- М.Сондор Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 8 анги
- Б.Жаргалмаа 15 дугаар сургуулийн 8б анги
- Г.Номинжин Оюуны-Ирээдүй цогцолбор сургуулийн 5-6 анги
- Б.Мөнхсарнай Хонгор сумын 14 сургуулийн 8б анги
- Т.Эрхэмбаяр 2 дугаар сургуулийн 6а анги
- ✓ 9-12 дугаар анги: - Г.Ганчимэг Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 11а анги
- Ш.Отгончимэг 9 дүгээр сургуулийн 9в анги
- Лхагвадаш Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 9а анги
- ✓ Насанд хүрэгчид: - Ц.Золжаргал 1 дүгээр цэцэрлэгийн багш
- Д.Лида Дархан сумын Өндөр настан



В) БАГТ НААДМЫН ДҮРИЙН УРАЛДААНЫг зохион байгуулан шалгарууллаа.
(100 гаруй хүн оролцсон)



Г) "ХОС БИЧИГТЭН" ЦАХИМ БИЧВЭР, ТҮРГЭН УНШЛАГЫН УРАЛДААН БОЛОВ

"Үндэсний бичиг үсгийн баярын өдөр"-өөр аймгийн Төрийн албан хаагчдад чиглэсэн үйл ажиллагаанууд зохион байгуулсан бөгөөд Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөл, Соёл урлагийн газар, Хэлний бодлогын зөвлөлтэй хамтран "ХОС БИЧИГТЭН" цахим бичвэр, түргэн уншлагын уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд нийт 11 байгууллагын 23 ажилтан, албан хаагч оролцож үндэсний бичгээрээ унших, өгөгдсөн эхийг хөрвүүлэн цахим бичвэрт буулгах чадвараа сорьсон бөгөөд

Цахим бичвэрийн уралдааны:

- ✓ 1 дүгээр байранд Шинэ Алхам сургуулийн багш н.Наранцэцэг
- ✓ 2 дугаар байранд Дархан сумын ИТХурлын ажлын албаны ажилтан Ц.Шинэцэцэг
- ✓ 3 дугаар байранд Аймгийн ЗДТГазрын ажилтан Х. Учрал
- ✓ Тусгай байранд Төв номын сангийн номын санч Н.Норжмаа

Түргэн уншлагын уралдааны:

- ✓ 1 дүгээр байранд Дархан сумын ИТХ-ын ажлын албаны ажилтан Ц.Шинэцэцэг
- ✓ 2 дугаар байранд Төв номын сангийн номын санч О.Дунжидмаа
- ✓ 3 дугаар байранд 24-р цэцэрлэгийн багш н.Алтанчимэг
- ✓ Тусгай байранд ГХБХБГазрын мэргэжилтэн Ц.Чулуунцэцэг нар амжилттай оролцлоо.
- ✓





Номын баярын үйл ажиллагааны тоон мэдээ

Д/Д	Зохион байгуулагдах ажлууд	Хэдэн удаа	Хүний тоо	Хариуцах эзэн	Гүйцэтгэл
1	"Хаврын номын баяр-2023" нээлтийн үйл ажиллагаа	1	1500	20 ААНБ хамтран оролцов.	Залуучууд театрын 1 дүгээр давхарт
2	"Оюунлаг Дархан" өдөрлөг	2	350	Их дээд, ЕБС	ХУИС, ОИЦ
3	Номын сангийн тухай, хууль эрх зүйн баримтын сургалт, сурталчилгаа	1	35	Г.Нямцэнд, С.Нэргүй	Төв номын сан, Их дээд болон ЕБС-ийн номын санчид оролцов.
4	Тэргүүний уншигч хамт олон шалгаруулах үйл ажиллагаа	1	168	ЕБС	Тэргүүний уншигч хамт олон
5	"Уншаад урагшлахуй" ном уншлагыг сурталчлах, сэдэлжүүлэх сургалт	7	450	Уншлага үйлчилгээний номын санчид	15 минутын уншлага зохион байгуулав.
6	"Номын өргөөний ид шид" лекц танилцуулга	12	380		Номын сангийн lib4u програм нийт 12 удаа нийт 380 хүнд танилцуулга хийв
7	"Үлгэрээс үлгэрлэе" чанга уншлага, тойм яриа	12	536		Монголын болон Дэлхий дахины сонгодог үлгэрүүдээр СӨБ-ын байгууллагуудаар зохион байгуулав.
8	"Номын эзэн"-ийг алдаршуулах, бэлэглэх ёслол "Ном"		752	Номын санчид	Иргэд, ААН байгууллагаас хандив өргөсөн, хөрөнгө оруулсан хувь хүн, албан байгууллагыг урамшуулан алдаршуулав. Нийтдээ 752 боть ном цугларч, 618 боть номыг 2 багийн төв дээр өгч, 134 боть номыг номын сангийн орлогод бүртгэн авлаа.
9	Орон нутаг дахь хэвлэлийн үйлдвэрүүдээс хэвлэгдсэн номын үзэсгэлэн, ном зүйн бүртгэл	1	5	Х.Отгонбаяр	2023 онд Хэвлэлийн бүтээгдэхүүний судалгаа хийж гаргах

10	“Бийрээ нийлье” үндэсний бичгийн уралдаан	1	56	Хэлний бодлогын зөвлөл	ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулж, 1-3-р байр эзлүүлэн дүгнэв.
11	“Ургаа удалъя” угийн бичгийн сургалт, уралдаан	1	45		Багийн ахмадын зөвлөлтэй хамтран зохион байуулав.
12	Цахим бичвэрийн уралдаан	1	36	Хэлний бодлогын зөвлөл	Аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд Төрийн албан хаагчдын дунд зохион байгууллаа.
13	Монгол бичгийн түргэн уншлагын уралдаан	2	146	МАА, ЗАА, Уншлага үйлчилгээ	Төрийн албан хаагчдад болон ЕБС-ийн сурагчид, насанд хүрэгчдийн дунд 2 удаа зохион байгууллаа.
14	Уран уншлагын уралдаан	2	110	ЕБС-иуд, СӨББ-ын багш нар	Богино өгүүллэгийн уралдааныг 2 үе шаттай зохион байгуулж, СӨБ, ЕБС, насанд хүрэгчид амжилттай оролцов
15	Англи номын орчуулгын уралдаан	1	86	Аймгийн Төв номын сан	ЕБС, насанд хүрэгчид
16	“Үндэсний бичиг үсгийн баяр”-ын хүрээнд Төв номын сангаас аймгийн нийт Төрийн алба хаагчдад зориулан “Миний Монгол бичиг” сургалт, өдөрлөг	1	80	Залуучуудын хөгжлийн төв	Боловсрол судлалын ухааны доктор Ц.Буянхишиг, 30 дугаар сургуулийн сургалтын менежер Ж.Эрхэмсайхан нар лекц тавилаа.
17	Зохиолын баатруудын дүрийн уралдааны шагнал гардуулах шалгарсан багийн парад	1	80	ЕБС, СӨББ	Залуучууд театрын дэргэдэх Дионис драмын дугуйлангийн сурагчидтай хамтран зохион байгуулав.
18	Номын клуб, ном сонирхогчдын уулзалт	1	30	Сайн дурын уншигчид	Сургуулийн номын санчид, Номын клубын оюутан сурагчид
19	“Мэдлэг ба сэтгэлгээ” өдрийн тэмдэглэл шинэ номын нээлт	1	40	Уншлага үйлчилгээний нэгж, ЗАА нэгж	Радио телевизийн Тэргүүний ажилтан, МҮОНРТ-ийн ахмад ажилтан Д.Жамсрангийн “ШИНЭ НОМЫН БАЯР”-ыг зохион байгуулж, уншигчид, найз нөхөд нь оролцов.
20	“Зохиолч – Хүүхэд” уулзалт	1	50	Номын санчид	Уулзалтанд ОИЦ сургуулийн 6-11 анги, Од цогцолбор сургуулийн 10-2 ангийн сурагчид оролцож “Уутан хацарт” номын талаар, зохиолын дүрүүд, зургийн талаарх сонирхолтой ярилцлагуудыг өрнүүлэн, чөлөөт ярилцлага хийв
21	Ахмад номын санчдын уулзалт	3	187	Цахимаар болон танхимаар	Туршлага судлах, номын санч мэргэжлийг сурталчлах
22	Ховор хуучин номын худалдаа	2	350	Баг ахмадын хороотой хамтрах	
23	Орон нутгийн зохиолчдын гарын үсэгтэй номын худалдаа	1	35	Хүүхдийн номын ордон	Орон нутгийн зохиолчидтой хамтрах

24	Ном хэвлэлийн хүрэлцээ хангамжийн судалгаа	1	50		Иргэд олон нийтийн оролцоонд тулгуурлан цаасаар авав
25	Уншигчдын сэтгэл ханамжийн судалгаа	1	50		
26	Боловсролын хөтөлбөрийн танилцуулга	2	88		УБ төмөр замын галт "Аялалын галт тэрэгний тусгай хөтөлбөрөөр
27	Боловсролын хөтөлбөрийн сургалт	2	88		УБ төмөр замын галт "Аялалын галт тэрэгний тусгай хөтөлбөрөөр
28	Хөгжөөнт тоглоом	1	500		ЕБС-ийн сурагчдад "Мэдлэг сорих" хөгжөөнт тоглоом
29	Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн	3	490	Найрамдал талбайд болон танхимаар	"Номын баяр бидний баяр", "Хүүхдийн баяр", Англи номын үзэсгэлэнгүүдийг гаргаж иргэдийн хүртээл болгов.
		63	6283		
1	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжсэн төрөл бүрийн материалаар хийсэн судрын баринтаг оёж, үзэсгэлэн	1	15	Залуучуудын хөгжлийн төв	ШУТИС, МСҮТ-ийн оёдлын анги, Эмэгтэйчүүдийн холбоо
2	Соёлын өв, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн, 100 гаруй ном, 120 гаруй үзмэр	1	220	Залуучууд хөгжлийн газар	Аймгийн Музейгээс "монголчуудын хэрэглэж ирсэн бичгийн хэрэгсэл" үзэсгэлэн, 30 дугаар сургууль, Од цогцолбор сургуулийн багш, сурагчдын бүтээлээр үзэсгэлэн гаргав.
3	Уншигч хүүхдүүдийн бүтээл, номын тэмдэглэл үзэсгэлэн	1	2500	17 аж ахуйн нэгж, Их дээд, ЕБСургууль, сургуулийн номын санчид	17 аж ахуйн нэгж болон Тэргүүний уншигч хүүхдүүдийн номын тэмдэглэл хөтлөх болон зурах материалаар үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.
4	Тэгш ой /80,90,100/ ойн тохиож буй зохиолчдын бүтээлийн үзэсгэлэн	2	216	Зохиолчдын холбоо	Судалгааны үндсэн дээр үзэсгэлэн гаргах
5	Ховор хуучин номын худалдаа	2	350	Баг ахмадын хороотой хамтрах	
6	Орон нутгийн зохиолчдын гарын үсэгтэй номын худалдаа	1	35	Хүүхдийн номын ордон	Орон нутгийн зохиолчидтой хамтрах
7	Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн	3	177	Найрамдал талбайд болон танхимаар	"Номын баяр бидний баяр", "Хүүхдийн баяр", Англи номын үзэсгэлэнгүүдийг тус тус гаргав
8	"УУТАН ХАЦАРТ" номын зохиолч МУСГЗ, сэтгүүлч Ө.Рагчаасүрэн болон зураач Б.Нямдаваа нарын эх зургийн бүтээлийн үзэсгэлэн	1	120		"ЗОХИОЛЧ ба УНШИГЧ" сэдэвчилсэн үзэсгэлэнд номын бүтээлийн эх зургууд, ном, хэвлэлийн бүтээлүүдээр тавигдав.

9	Ахмад номын санчдын уулзалт	1	600		Номын санчдын мэргэжлийг оюутан залуучуудад сурталчлах
		13	4233		

ХҮҮХДИЙН НОМЫН ОРДОН:

Нийт 6 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг 9 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 650 гаруй уншигч, хэрэглэгчдийг оролцуулсан байна.

Нэг: Зохион байгуулалт

1.1. Бүх нийтийн соёл, мэдээлэл, боловсролыг олгоход чиглэсэн бүтээлч үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд:

Чанга уншлага: “Үндэсний бичиг соёл-Номын өдөр”-ийг тохиолдуулан 13 дугаар цэцэрлэгийн бэлтгэл, ахлах 6 бүлэг, Цайхун сургуулийн Ж.Мөнхжаргал багштай 16 анги хамт олон, эцэг эхчүүдийн төлөөлөл, 25 дугаар цэцэрлэгийн бэлтгэл, ахлах, дунд, бага бүлгийн нийт **293 хүүхдэд** “Цэцэн туулай”, Эрхий мэргэн харваач” болон “Царс зэгс хоёр” хормогчин хэлбэрт том номоор чанга уншлага хийж, цэцэрлэгийн насны хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон зурагт ном үзүүлсэн.



1.2. Үзүүлэн таниулах ажлын хүрээнд:

Номын үзэсгэлэн: “Үндэсний бичиг соёл- Номын өдөр”-ийг тохиолдуулан өөрийн сан хөмрөг дэх эх хэл, түүх соёл, үндэсний бичиг, танин мэдэхүйн холбогдолтой номуудыг уншигч хэрэглэгчдэд танилцуулах, сан хөмрөгийн эргэлтийг сайжруулах зорилгоор сэдэвчилсэн номын үзэсгэлэнг **59 боть** номоор гаргаж, мөн цахим хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд байршуулан **457 хэрэглэгчдэд** хүргэсэн.

Уншигч хүүхдүүдийн бүтээлийн үзэсгэлэн: “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан “Од” цогцолбор сургуулийн Мягмаржаргал багштай 4-10 анги, Л.Оюун багштай 5-10 анги, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн Х.Туяа багштай 5г ангийн сурагчдын бүтээлийн болон номын тэмдэглэлийн үзэсгэлэнг 2023 оны 05 дугаар сарын 09-нд “Залуучууд” театрт зохион байгуулсан нэгдсэн нээлтийн үйл ажиллагаанд арга дэлгэн тавьж, 300 гаруй оролцогчдод хүргэсэн.



1.3. Уралдаан, тэмцээн зохион байгуулах чиглэлийн хүрээнд:

"ОИЦ" сургуулийн 3-8 ангийн сурагчид хичээлээс гадна өөрсдийн мэдлэг чадвараа дээшлүүлж "Хүүхдийн Номын Ордон"-ы англи хэлний танхимд хамрагдан суралцаж, уг хичээлээр олж авсан мэдлэгээ бататган тайлан тоглолтоо 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдөр амжилттай үзүүлсэн.



1.4. Уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хүрээнд:

Номын клубын уулзалт: "Үндэсний бичиг үсгийн баярын өдөр"-ийг угтаж "Өглөөний цайтай уншлага" арга хэмжээг "Од" цогцолбор сургуулийн "Ухаарлын толь" номын клубийн 6-9-р ангийн 26 сурагчдын дунд "Хүмүүн бичиг" сониноос уншлага зохион байгуулж, уншсан сэдвүүдээрээ бие биендээ мэдээлэл хийлээ. Мөн Хүүхдийн номын ордны танилцуулга мэдээлэл хүргэн цаашид тус клубтэй хэрхэн хамтран ажиллах боломжийн талаар ярилцлаа.



Угийн бичгийн сургалт: Хүүхдийн номын ордны Салбар номын сангийн идэвхтэн уншигч 5-8 дугаар ангийн 25 гаруй сурагчдад угийн бичиг хөтлөх, ач холбогдол, арга зүйн талаар сургагч багш, номын санч- мэдээллийн ажилтан С.Оюунцэцэг сургалт зохион байгууллаа.



1.5. Хуучин номын болон зохиолчдын гарын үсэгтэй номын худалдаа зохион байгуулах ажлын хүрээнд:

2023 оны 05 дугаар сарын 19-нд “Залуучууд” театрт зохион байгуулагдсан нэгдсэн нээлтийн үеэр хуучин номын болон зохиолчдын гарын үсэгтэй номын худалдааг зохион байгуулсан.



1.6. Номын баярын нэгдсэн үйл ажиллагаанд оролцох чиглэлийн хүрээнд:

“Номын баярын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Номын баяр-Хүүхэд бүр уншигч” уриан дор Дархан хотноо 2023 оны 05 дугаар сарын 19-нд аймгийн Соёл, урлагийн газар, аймгийн төв номын сангаас зохион байгуулсан нэгдсэн нээлтийн үйл ажиллагаанд хамтран оролцож;

- ✓ “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан анги, сурагчийг шалгаруулах;
- ✓ “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан ангийн бүтээлийн үзэсгэлэн гаргах;
- ✓ Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан ангийн үзүүлэх тоглолт зохион байгуулах;
- ✓ “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан ангийн сурагчдийн дунд АХА тэмцээн зохион байгуулах;
- ✓ Хүүхдийн Номын Ордны танилцуулга үзэсгэлэн бэлтгэх, гаргах;

- ✓ Хүүхдийн Номын Ордны ажилтан албан хаагчдын “Миний нэрийн хуудас” монгол бичгийн бичвэрийн үзэсгэлэн гаргах;
- ✓ Уншигчдын карт 50% хөнгөлөлттэй үнээр нээх;
- ✓ Хуучин номын худалдаа зохион байгуулах;
- ✓ Зохиолчдын гарын үсэгтэй номын худалдаа зохион байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж нийт 250 гаруй хүүхэд багачуудыг хамруулж, номын сан, соёлын үйлчилгээ үзүүлсэн.



ШАРЫН ГОЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВ:

1. Үндэсний бичгээр галиглах “АХА” тэмцээн

“Үндэсний бичиг үсгийн баяр 2023”-ыг тохиолдуулан монгол бичиг анхлан суралцаж буй Ерөнхий боловсролын 2, 6 дугаар сургуулийн 6 дугаар ангийн сурагчдын дунд “АХА” тэмцээн зохион байгуулсан.



АХА тэмцээнд 2 сургуулийн 45 сурагч хамрагдсанаас:

- Тэргүүн байранд 2 дугаар сургуулийн 6в ангийн сурагч Г.Эрдэнэхишиг
- Дэд байранд 6 дугаар сургуулийн 6а ангийн сурагч К.Бүрлен нар шалгарлаа.



2. “Үндэсний бичгээрээ ковер зургаа шинэчилье” аян

Аянд нийт 15 иргэн, хүүхэд багачууд нэгдсэн.



3. Үндэсний бичгээр хэвлэгдэн гарсан номнуудаа дэлгэн танилцуулсан.



НЭГТГЭЛ: Үндэсний бичиг үсгийн баярыг угтан 4 ажил төлөвлөснөөс 1 нь багш нарын үнэлгээний шалгалт давхцсантай холбогдуулан тодорхой хугацаагаар хойшилж, **75%** хийгдлээ. Үүнд: танхимаар 1 ажилд 45 хүн хамрагдаж, цахимаар явуулсан 2 ажил **947** хүнд хүрлээ.

4. “Судар Эрдэнэ” богино өгүүллэгийн уралдаан

-Аймгийн Төв номын сангаас санаачлан зарласан “СУДАР ЭРДЭНЭ” богино өгүүллэгийн уралдаанд дугуйлангийн 15 хүүхдийн бичлэг хийж оролцлоо.

Сургуулийн бага насанд:

1. 4в Б.Гэгээ “Айлын ганц хүүхэд”
2. 4в О.Анирмаа “Эхийн хайр”
3. 4в А.Жулдыз “Баян эмээ”
4. 4в Г.Анхмаа “Эжжийнхээ ачийг хариулах юмсан”
5. 4в А.Баярцэцэг “Шалгалт”
6. 4в У. Амина “Шинэ дээл”
7. 5в О.Сумьяа “Цогоо”
8. 5б Г.Нямжаргал “Нагац эгч хэрхэн оёж сурснаа өгүүлсэн нь”
9. 5б А.Цэлмүүн “Хаягдмал хүүхэд”
10. 5б А.Айша “Чавганы яс”

Сургуулийн дунд насны төрөлд:

1. 6а А.Отгончимэг “Ангаахай
2. 6а Т.Эрхэмбаяр “Би том болдог болов уу?”
3. 8б М.Сондор “Цусан өшөө”
4. 9а Лхагвадаш “Эсгий үнэгний дууль

Сургуулийн ахлах насанд:

1. 11-3 Г.Ганчимэг “Суурин газрын зочин” зэрэг хүүхдүүдийг оролцуулаа.

5. “Хаврын найраг” сумын зохиолч яруу найрагчдын уран бүтээлийг дүрсжүүлэн үзэгчдэд хүргэсэн.

МЗЭ-ийн Дархан-Уул аймгийн салбарын харьяа Шарын гол сумын зохиолчдын нэгдлийн **6** яруу найрагч, сонирхогч **4** хүүхдийн уран бүтээлийг дүрсжүүлэн олон нийтийн хүртээл болголоо.



Үүнд:

1. Зохиолчдын нэгдлийн тэргүүн Д.Энх-Октябрь “Ханьдаа”
2. Ц.Төмөрхуяг “Шүлэг минь”
3. О.Цэцэгмаа “Нутаг минь”
4. Д.Наранцэцэг “Багш”
5. Ж.Нарантуяа “Бурхан ийжидээ” зэрэг шүлгүүдээ уншлаа. Мөн Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн шүлэг яруу найраг сонирхогч 4 сурагч мөн үйл ажиллагаанд хамрагдсан.

Дүрс бичлэгийг 2023 оны 05 дугаар сарын 07-ны өдөр авч, эвлүүлэн үзэгчдэд хүргэж 3 уран бүтээлчийн контент цахимаар **6.9 мянган** хүнд хүрсэн.

6. Цэцэрлэгийн багачуудад зориулсан “Үлгэрийн богц” арга хэмжээ:

Тус арга хэмжээний хүрээнд Шарын гол суманд үйл ажиллагаа явуулдаг 14, 17, 2, 19 -р цэцэрлэгийн нийт **159** багачуудад номын санг танилцуулж, хүссэн үлгэрийг уншиж өгөн ярилцлаа. “Үлгэрийн богц” аялал нь дахиад үлгэр уншаад өгөөч гэх бяцхан хүүхдүүдийн яриагаар дүүрэн өнгөрлөө.



7. “Цэвэр агаарт тархиа цэнэглээ” хээрийн уншлага

Сумын төв Найрамдал талбай, сургуулийн саравч, уулын энгэр, наадмын талбай зэрэг газруудад нийт 58 хүүхэд хээрийн уншлага хийж тархиа сэргээлээ.

8. “Номоо эмчилье”

2 дугаар сургуулийн 8а ангийн хүүхдүүдтэй номын санч хамтран өвлийн турш хамгийн их уншигдсан хүүхдийн **300** орчим номыг арчиж, урагдаж салсан **28** ширхэг ном нааж эмчиллээ.

9. “Номын богцтой болцгооё”



Сумын номын сантай байнга хамтран ажилладаг ЕБС, цэцэрлэгүүд номын санчид богц урлаж өглөө. Одоогоор 14, 17 дугаар цэцэрлэгүүд богцоо ирүүлээд байна. Цаашид 4 нэмэгдэх бөгөөд уг богцнуудаа явуулын уншлага хийх, хүргэлтийн ном өгөх үед ашиглах юм.

10. “Ганцаараа биш олуулаа уншья” хандивын аян

Хандивын аянд 2 байгууллага, 4 иргэн нэгдэж, нийт **169** ном хандивласан.



11. “Номтой төрийн албан хаагч” аян

Аяны хүрээнд 14 дүгээр цэцэрлэгийн 8 багш ажилтан уншигчийн зарт нээлгэж, номын сангийн үйлчлүүлэгч боллоо.

Эхний хагас жилийн хамгийн олон ном уншсан төрийн албан хаагчаар 17 дугаар цэцэрлэгийн ажилтан Сүнжидмаа шалгарлаа.



12. “Миний ном” сумын зохиолч , яруу найрагчдын хэвлүүлэн гаргасан номыг олон нийтэд сурталчлан таниулах

Шарын гол сумаас төрөн гарсан 5 зохиолчийн уран бүтээлийн дээж болсон 5 номыг танилцууллаа.

1. Ахмад багш асан С.Барийсан “Алдраа нь үгүй сэтгэл”
2. Л.Гэрэлтуяа “Сэтгэлийн сувдан хэлхээ”
3. М.Наранцэцэг “Сутгалийн гүндэх ертөнц”
4. Х.Энхтайван “Шарын гол шайбьай хоккей”
5. Д.Отгонбаяр “Анир хөглөсөн нутаг” зэрэг номнуудыг сурталчилсан.

13. Өглөө бүрийг сургамжит өгүүллэгээр эхэлье.

6 дугаар сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдын дунд эхлүүлсэн уг аянд 6 ангийн 170 орчим хүүхэд хамрагдлаа.



14. “Номтой оюунлаг шарын голчууд” номын баярын өдөрлөг арга хэмжээ

Зуны тэргүүн улаагчин могой сарын шинийн нэгний билигт сайн өдөр “Номтой оюунлаг шарын голчууд” уриан дор “ҮНДЭСНИЙ НОМЫН БАЯР 2023”-аа тэмдэглэн өнгөрүүллээ. Өдөрлөг арга хэмжээнд 132 хүн оролцон, номын өртөөнд саатаж, өөрт хэрэгтэй мэдээллээ авлаа.



Тус баярын нээлтийг “Цэцэг” хамтлагийн ном дуугаар эхлүүлж, уран жиргээ аймгийн уралдааны тэргүүн байрын шагналт Т.Эрхэмбаяр “Би том болдог болов уу?” өгүүллэгээ уншиж сонирхууллаа.

Номын баярын өдөрлөгийг уншигчдад илүү хүргэх зорилгоор: “Бүтээлч уншлагын өртөө”, “Хандивын ном, Номын богц хүлээн авах өртөө”, “Сэдэвчилсэн номын өртөө”, “Уншигчдын уулзалтын өртөө”, “Номын тэмдэглэлтэй танилцах өртөө” гэх мэтээр ӨРТӨӨЧИЛСӨН хэлбэрээр зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр “ГАНЦААРАА БИШ ОЛУУЛАА УНШЬЯ” аяны хүрээнд 2 иргэн, 2 цэцэрлэгийн хамт олон зорин ирж ном хандивлан, Ерөнхий боловсролын 2 болон 6 дугаар сургуулийн номын санчид сурагчдын уншсан номын тэмдэглэл, ховор нандин номоо дэлгэн танилцууллаа.



“ДАРХАН ЭНХ ҮҮД НОМЫН ДЭЛГҮҮР”-ийн хамт олон хамтран ажиллаж 10 гаруй иргэн номын худалдаа хийж, оюундаа хөрөнгө орууллаа.

Үр дүнтэй, хамгийн олон ном уншсан 2 дугаар сургуулийн С.Ариунчимэг Ariunchimeg Sukhbaatar багштай 4в, Д.Ганцэцэг багштай 3б ангийн хамт олон Тэргүүний уншигч “Нацагдорж” тэмдэгтэн боллоо.

1. Хамгийн олон ном уншсан “Оюунлаг төрийн албан хаагч”- аар 17 дугаар цэцэрлэгийн ажилтан Сүнжидмаа
2. Хамгийн бүтээлч уншигчаар “Буяны үр” шүдний эмнэлгийн их эмч Ц.Баасанжав
3. Хамгийн олон ном уншсан хүүхдээр 4в ангийн сурагч Н.Жулдыз
4. Хамгийн бяцхан уншигчаар 1в ангийн сурагч Б.Жигүүр хүү тус тус шалгарлаа.



Шарын гол сумын соёлын төв нь Үндэсний бичиг соёл, номын баяраар 13 арга хэмжээг 1 удаа зохион байгуулж нийт 593 иргэд олон нийтийг хамрууллаа.

ХОНГОР СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН НИЙТИЙН НОМЫН САН:


1. Хонгор сумын Эрүүл мэндийн төвийн хамт олонд Нийтийн номын сангаас гар утсандаа үндэсний бичгийн өргөн хэрэглээний программ ашиглах тухай сургалтын хүрээнд "Хүний нэрийн толь" ба "Тунгаамал" толийг өдөр тутамдаа хэрхэн ашиглах талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.



2. 14 дүгээр сургуулийн 7а, 8б ангийн сурагчдын дунд Танин мэдэхүйн "АХА" тэмцээн, "Цэвэр бичигтэн" уралдааныг зохион байгуулав.



3. Хонгор сумын 16 дугаар цэцэрлэгийн багш, ажилчдад "Tungaamal", "Chimege" аппликэйшн дээр ажиллах монгол бичгийн гарыг компьютерт суулгах, бичих хичээл заалаа.



Тус номын сан нь үндэсний бичиг үсэг, номын өдрүүдийн баяраар нийт 4 арга хэмжээг 1 удаа зохион байгуулж 230 иргэд, олон нийтийг хамрууллаа.

ОРХОН СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН НИЙТИЙН НОМЫН САН:

“Үндэсний бичиг үсэг, номын баяр-2023”-ын хүрээнд:

1. Орхон сумын иргэд, Төр төсвийн байгууллагын албан хаагчдын дунд ҮГ Б.Булган, АЯ Г.Нямсүрэн “Орхон нутаг” дууг алдаагүй зөв цэвэр гаргацтай хүссэн материал дээрээ бийрээр болон үзгээр бичих үйл ажиллагаа зохион байгуулж нийт оролцогчдоос 15 бүтээл ирсэн. Үүнд:

- ✓ I байр ЕБС-ийн Монгол хэлний багш Ц.Цэрэнпагам мөнгөн шагнал, өргөмжлөл
- ✓ II байр Соёлын төвийн ажилтан Н.Уянмөнх мөнгөн шагнал, өргөмжлөл
- ✓ III байр Соёлын төвийн Номын санч М.Оюунчимэг мөнгөн шагнал, өргөмжлөл

2. Номын сайн нөхөр анги, хамт олныг алдаршуулж, сурагчид өөрсдийн бэлтгэсэн бүтээлийн үзэсгэлэнг дэлгэж мөн дүрийн тоглолт, ая дуугаа өргөн барив.

3. Соёлын төвийн номын сангийн номын фондыг баяжуулахын тулд номын хандивын аян зарлаж, үндэсний бичиг үсэг, номын баяраар “Бүтээлт ногоон гүүр” ТББ-гаас 80 ширхэг ном, Хонгор сумын ЗДТГ-аас 15 ширхэг ном, иргэдээс 3 ширхэг ном, нийт 98 ширхэг номын хандивыг хүлээн авсан. Тус номын баяраар 95 хүүхдэд уншигчийн карт нээлгэж танхимаар 120, гэрээр 7 ном олгосон нийт уншигчид 127 номоор үйлчилж ажиллалаа.



Тус номын сан нь үндэсний бичиг үсэг, номын өдрүүдийн баяраар нийт 3 арга хэмжээг 1 удаа зохион байгуулж 147 иргэд, олон нийтийг хамрууллаа.

**СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ХАРЬЯА НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН “ҮНДЭСНИЙ
БИЧИГ ҮСЭГ, НОМЫН ӨДРҮҮД-2023” БАЯРААР ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТОО, ХАМРАГДСАН ХҮНИЙ НЭГДСЭН ТОО**

2023.06.05

Дархан-Уул аймаг

№	Байгууллагын нэр	Зохиосон арга хэмжээний тоо	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо
1	Төв номын сан	38	76	10,516
2	Хүүхдийн номын ордон	8	9	650
3	Шарын гол сумын соёлын төвийн номын сан	13	1	593
4	Хонгор сумын соёлын төвийн номын сан	4	1	230
5	Орхон сумын соёлын төвийн номын сан	3	1	147
Нийт		66	88	12,136

ХЯНАСАН:

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Б.ДОЛГОРМАА